

ЭХ НЯРАЙ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ-II

**ХҮНИЙ НӨӨЦИЙН АЛБАНЫ
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТ**

2023 он

Гарчиг

Нэг. Хүний нөөцийн удирдлага

Хоёр. Хүний нөөцийн төлөвлөлт

Гурав. Хүний нөөцийн шилжилт хөдөлгөөн

Дөрөв. Шагнал урамшуулал

Тав. Сахилгын шийтгэл

Зургаа. Хүний нөөцийн сургалт

Долоо. Төвийн ажилтнуудын нийгмийн баталгааг хангах арга хэмжээ

Найм. Хууль тогтоомжийн хэрэгжилт

Ес. Программ хангамж

Арав. Дотоод болон олон нийтийн үйл ажиллагаа

Арван нэг. Албан хэрэг хөтлөлт

Арван хоёр. Хавсралт

Нэг. Хүний нөөцийн удирдлага

Хүний нөөцийн алба нь Эх нярай эмэгтэйчүүдийн үндэсний төвийн дүрэм, бүтэц үйл ажиллагааны дагуу албаны дарга, хүний нөөцийн менежер 1 гэсэн 2 хүний бүрэлдэхүүнтэйгээр төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан, албан хаагч нарыг стандартанд заагдсан орон тоогоор, хөдөлмөрийн аюулгүй, цэвэр орчинд ажиллах, тэдний сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, хүний нөөцийг бүрдүүлэх, ур чадвар, мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх, нийгмийн баталгааг хангах, сэтгэлзүйн болон эрүүл мэндийн нийгмийн үйлчилгээ үзүүлэх зорилготойгоор үйл ажиллагаа ил тод зохион байгуулан ажиллаж байна.

Төвд нийт 440 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан ажил үүрэг гүйцэтгэсэн ба удирдах ажилтан 4, их эмч 121, эм зүйч 6, эм найруулагч 1, сувилагч 57, эх баригч 47, эмнэлгийн тусгай мэргэжилтэн 14, туслах сувилагч 31 эрүүл мэндийн нийгмийн ажилтан 2, эмнэлгийн бус дээд мэргэжилтэн 25, эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер 4, мэдээлэл технологийн инженер 1, бусад 119, гэрээт 8.

Мэргэжлийн зэргийн шалгалтад 3 эмч, 3 эх баригч, 3 сувилагч ахлах, тэргүүлэх зэрэг хамгаалсан. Хөдөлмөрийн дотоод журмын дагуу зөвлөх зэрэгт 20, тэргүүлэх зэрэгт 15, ахлах зэрэгт 10 хувийн нэмэгдлийг олгож байна. Мөн 2 их эмч Анагаах Ухааны докторын, 9 их эмч Анагаах Ухааны магистрын, 2 сувилагч магистрын сургалтанд суралцаж байна.

Энэ онд нийт 5 эмчийн эмчлэх эрхийн, нийт 8 эмнэлгийн мэргэжилтний эх барих, сувилах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацаа дуусч тухайн ажилтнуудад мэдэгдсэн. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн хүний нөөцийн цахим системд 233 ажилтан бүртгэгдсэн. Лицензийн хүчинтэй хугацаанд хяналтыг хийж хугацаа дууссан 8 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд мэдэгдэж шалгалтын мэдэгдэл өгсөн.. Бүгд тэнцсэн.

Хоёр. Хүний нөөцийн төлөвлөлт:

Төвийн эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан нарын орон тооны судалгааг “Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа MNS6330:2017 стандарт, болон Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/529 дугаар тушаалаар баталсан дүрэм, бүтэц орон тоо батлах тухай тушаал, Ерөнхий захирлын 2023 оны А/01 дугаар тушаалуудыг мөрдөн ажиллаж байна. Орон тооны харьцуулалт хийж үзэхэд эмч, эмнэлгийн мэргэжилтэн шатлалын стандартанд заагдсан орон тоонд хүрэхгүй байна. Үүний шалтгаан нь шинээр байгуулагдсан хотын төвөөс алслагдсан байдагтай холбоотой байна.

Эмнэлгийн тусламж, үйлчилгээг гардан үзүүлдэг эмнэлгийн мэргэжилтэн, тусламж үйлчилгээг үзүүлэхэд шууд оролцдог эмнэлгийн мэргэжилтэн болон захиргаа, аж ахуйн үйлчилгээний ажилтны харьцаа **66%:34%**. Эмнэлгийн тусламж, үйлчилгээг гардан үзүүлж байгаа их эмч болон эх баригч,сувилагчийн харьцаа **1:1**, Лабораторийн тусламж, үйлчилгээг үзүүлэх лабораторийн их эмч, лаборант нарын харьцаа **1:1,5** байна.

2023 онд шаардлагатай орон тооны санал өгч, батлагдсан орон тоо **550**. Хүний нөөцийн хэрэгцээний төлөвлөлтийг ажилтны насны, стратеги, хөгжлийн төлөвлөгөөний судалгаагаар 2023 он хүртэл төлөвлөн, хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж байна. 2024 онд А/01 тушаалын төслийг гаргахаар дэд захирал, тасгийн эрхлэгч, албадын дарга нарт дотоод албан бичгийг явуулсан.

Гурав. Хүний нөөцийн шилжилт хөдөлгөөн:

Ерөнхий захирлын 2022 оны А/90 дүгээр тушаалыг мөрдөн сул болон шинэ ажлын байрны зарыг төвийн цахим хуудас, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Олон нийтийн цахим сүлжээ болон Facebookийн Эрүүл мэндийн ажилчдын нэгдсэн групп, Эх нярай эмэгтэйчүүдийн үндэсний төв-II групп, Хан-Уул дүүргийн 21-р хорооны зарын групп, Буянт Ухаа-2 хороолол, Шүрт хотхоны групп, Эмч, эмнэлгийн ажилтны ажлын байр, Монголын сувилагч нарын нэгдсэн группүүдэд ажлын байрны зарыг сар бүрийн давтамжтайгаар 12 удаа шинэчлэн байршуулсан.

Төвийн гадаад цахим хуудсаар 15, иргэн өөрийн биеэр 151, нийт 166 иргэний анкетыг хүлээн авч холбогдох алба, дэд захиралуудад танилцуулан сонгон шалгаруулалтын журмын дагуу 156 ажилтанг ажилд авсан. Үүнээс их эмч 42, сувилагч 22, эх баригч 17, бусад тусгай мэргэжилтэн 47, бусад ажилтан 21 хүүхэд асрах чөлөөнөөс ажилдаа эргэж орсон 7 байна.

Ажлаас чөлөөлөгдсөн 122, үүнээс өөрийн хүсэлтээр 115, тэтгэвэрт гарсан 1 ажил олгогчийн санаачлагаар 7, жирэмсний болон амаржсаны амралт авсан 15 хүүхэд асрах чөлөө авсан 27

Төвийн нийт 440 ажилтны 303 ажилтан буюу 69 хувийг 2 жилээс дээш жил ажилласан ажилтнууд эзэлж байна.

2023 онд 22 үйлчлүүлэгчийг туслах сувилагчаар сургаж 8 үйлчлэгчийг туслах сувилагчаар шилжүүлэн ажиллуулсан.

Дөрөв. Шагнал урамшуулал:

Төрийн дээд шагнал

- “Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон” 3
- “Алтан гадас одон” 6
- “Хөдөлмөрийн хүндэт медаль”, 6

Засгийн газрын шагнал

- “Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан” 11
- Эрүүл мэндийн яамны “Жуух бичиг” 8

Нийт шагнаж шагналын дагалдах мөнгөн урамшуулалд 7.300.000 төгрөг олгосон.

Эх, нярай эмэгтэйчүүдийн үндэсний төв-II-ийн 2023 оны шилдгүүд

Төвийн хамт олон 2021 оны хийж гүйцэтгэсэн ажлаа дүгнэн, оны шилдгүүдээ үе шаттайгаар шалгаруулан, Удирдлагын зөвлөлийн хуралд тайлагнан баталгаажуулсан.

2023 оны шилдэг хамт олон:

•
“Шилдэг менежер ”

•
“Шилдэг эмч”

“Шилдэг залуу эмч”

•
“Шилдэг эх баригч”

•
“Шилдэг сувилагч”

•
“Шилдэг ажилтан”

Төвийн ерөнхий захирлын нэрэмжит шагнал:-аар 15 хүн шагнагдсан.

Тав. Сахилгын шийтгэл:

Төвийн ерөнхий захирлын тушаалаар хөдөлмөрийн дотоод журам зөрчсөн 8 ажилтанд сахилгын шийтгэл ногдуулж, үндсэн цалингийн 1 сарын хугацаатай 20 хувиар бууруулах арга хэмжээ авсан байна.

Зургаа. Хүний нөөцийн сургалт

Энэ онд хүний нөөцийн сургалтыг дараах чиглэлээр бусад алба, ажилтнуудтай хамтран зохион байгуулж сургалтын танилцуулга материал 2, гарын авлага 17 гаргасан.

- **Шинэ ажилтанд зориулсан сургалт:** “Шинэ ажилтанг чиглүүлж дадлагажуулах хөтөлбөр”-ийг Ерөнхий захирлын А/134 дугаар тушаалаар батлуулж үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Шинээр ажилд орж байгаа ажилтан, албан хаагч нарт төвийн эрхэм зорилго, үнэт зүйл, соёл, дүрэм, журам, албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээ, ёс зүй, чанарын тухай ойлголт, стандарт удирдамж, ариутгал халдваргүйтгэл, хөдөлмөрийн аюулгүй үйл ажиллагааны талаар Сургалт гадаад харилцааны албатай хамтран 126 шинэ ажилтанд чиглүүлэх сургалтыг явуулан баталгаажуулсан байна.
- **“Эрүүл мэндийн салбар дах жэндэрийн тэгш байдал”** Сувилахуйн албаны нийт давхардсан тоогоор 135 ажилтанд заасан.
- **“Хөдөлмөрийн дотоод журам”-ын танилцуулга сургалт:** Хоол үйлдвэрлэлийн тасаг, Аж ахуй хангамж инженер техникийн алба, Соёл үйлчилгээний албаны нийт 110 ажилтанд хийсэн.
- **“ХАСХОМ хэрхэн зөв гаргах тухай”** холбогдох удирдах албан тушаалтанд хийсэн.
- **Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл талаарх хууль эрх зүйн зохицуулалт”** сургалтыг нийт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий албан тушаалтнуудад зохион байгуулсан. /Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/295 тушаал/
- **Төгсөлтийн дараах сургалт:**
2023 төрөлжсөн мэргэшлийн сургалтад:
 - Эх ураг судлал-1
 - Эмэгтэйчүүдийн дотоод шүүрэл, үргүйдэл судлал-1
 - Хүүхдийн дүрс оношилгоо-1
 - Хүүхдийн мэдээгүйжүүлэг судлал-2
 - Хүүхдийн мэс засал судлал-1
 - Хүүхдийн чих хамар хоолойн судлал-2
 - Хүүхдийн уушги судлал-1
 - Чанарын менежер /хүүхэд/
 - Мэдээгүйжүүлэг судлалын сувилагч-2
 - Мэс заслын сувилагч-1
 - Нярайн сувилагч-1 суралцан төгссөн.
 - Туслах сувилагчаар 23 үйлчлэгч ажиллан суралцаж төгссөн.
 - Магистрын хөтөлбөрийг 2 эмч амжиллтай дүүргэсэн.

Гадаад оронд мэргэжил дээшлүүлэх сургалт:

- "Монгол-Швейцарийн хамтарсан хүүхдийн төсөл" (SMOPP)-ийн Олон улсын цахим сургалтанд ЭНЭҮТ-ийн хүүхдийн эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн дэд захирал У.Цэвэгмид, хүүхдийн эрчимт эмчилгээний эмч А.Зэвгээ, хүүхдийн

зохицуулагч эмч Э.Доржбурам, хүүхдийн уушгины эмч Б.Золзаяа, хүүхдийн эмч Э.Намуун нар хамрагдаж байна.

- Нярайн тасгийн Ж.Ринчин эмч Румин улсын Бухарест хотод зохион байгуулагдсан “Neonatal/Perinatal Medical Forum 2023” форумд оролцсон. БНСУ-ын “SOONCHUNHYANG UNIVERSITY MEDICAL CENTER” эмнэлэгт “Сувилагч, эх баригч нарын мэргэжил ур чадавхийг дээшлүүлэх” сургалтанд Сувилахуйн албаны дарга, эх баригч С.Оюун, БНХАУ-ын ӨМӨЗО-ОУМАУ-ны эмнэлэг дээр сувилагч Б. Амарзаяа нар хамрагдсан.
- Франц Улсын Парис хотод болсон Эх барих эмэгтэйчүүдийн эмч нарын FIGO XXIY хуралд Эмчилгээ эрхэлсэн дэд захирал Ж.Оюунцэцэг, Эх барих эмэгтэйчүүдийн эмч Б.Хулан нар оролцсон.
- Оросын Холбооны Улсын Санкт-Петербург хотын Хүүхдийн халдварт өвчин судлалын эрдэм шинжилгээ, эмнэлзүйн холбооны төв агентлагт болсон “Хүүхдийн өвчлөл ба Халдварт өвчин” сэдэвт сургалтанд Хүүхдийн эрчимт эмчилгээний эмч А.Зэвгээ, Хүүхдийн эмч Т.Тэгшжаргал, Б.Нямсүрэн нар 14 хоногийн хугацаатай хамрагдаж мэдлэг мэргэжилээ дээшлүүллээ.

Долоо. Төвийн ажилтнуудын нийгмийн баталгаа

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх заалтын дагуу 64,001,350 төгрөгийн хөдөлмөр хамгааллын хувцсаар нийт ажилтан, албан хаагчдыг хангасан. Үүнд: Эмч халат 156, эмч өмд цамц 213, сувилагч өмд цамц 134, үйлчлэгч өмч цамц 11, үйлчлэгч малгай 37, мэс заслын халат 100, мэс заслын углааш 17, хоол үйлдвэрлэлийн тасгийн ажилчдын хувцас 42 ширхэгийг олгосон.
- Томуу томуу төст өвчлөлийн үед ажилтнуудын дархлаа дэмжих арга хэмжээг зохион байгуулж 30.041.400 төгрөгний өртөг бүхий 2249,6 ш дархлаа дэмжих бүтээгдэхүүн тараасан.
- Ажилтнуудын бие бялдар, эрүүл илүүдэл жингүй байх ажлын хүрээнд 2023 оны 5 дугаар сарын 28-нд нийт ажилтнуудын дунд гар бөмбөг, сагсан бөмбөг, дартс төрлөөр спортын тэмцээнийг амжилттай зохион байгуулж Эх барих эмэгтэйчүүдийн эмнэлэг шилжин явах цомын эзэн болсон.
- Дэмжих үйлчилгээний эмнэлгийн бус ажилтан болон инженер, техникч, жолооч нар амралтын өдрүүдэд ууланд алхалтын баг бүрдүүлж явган аялалыг 5 удаа зохион байгуулсан.
- Эрүүл мэндийн ажилтны өдрийг “Идэвхтэй хөдөлгөөн” спортын арга хэмжээ хэлбэрээр зохион байгуулж 25.035.000 төгрөг зарцуулсан.
- Ажлын байрны тав тухтай орчинг бүрдүүлэх зорилгоор 56 сая төгрөгний 33 ширхэг буйданг алба, тасгуудад хуваарилан өгсөн.

- Эмч сувилагч эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэдлэг боловсролыг тасралтгүй дээшлүүлэх зорилгоор 6 давхарын сургалтын өрөөг тохижуулан, 12 иж бүрэн компьютерийг суурилуулан, номын сан байгуулан ажиллаж байна.
- Ажилтнуудыг бага хүүтэй цалингийн болон хэрэглээний зээл, ипотекийн зээлд хамруулах ажлын хүрээнд Худалдаа хөгжлийн банктэй хамтран ажиллаж 6 ажилтан орон сууцны ипотекийн зээлд хамрагдсан.
- Эрүүл мэндийн ажилтны төрсөн аав, ээж, эхнэр (нөхөр), үр хүүхэд зэрэг гэр бүлийн аль нэг гишүүнд жилд нэг удаа эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хөнгөлттэй үзүүлэх боломжийг судлан, шийдвэрлэх зорилгоор Хөдөлмөрийн дотоод журмын 15 дугаар зүйлд нийгмийн асуудал шийдвэрлэх талаар 9 заалт бүхий ажлыг оруулж 2023 оны 11 сарын байдлаар 15 ажилтанд цалинтай, 30 ажилтанд цалингүй чөлөө олгосон.
- Туслах сувилагчаар 23 үйлчлэгч ажиллан суралцаж төгссөн.
- Сувилагч мэргэжлээр суралцагсдыг дэмжин Глобал Удирдагч Их сургуулийн Сувилахуйн сургуультай хамтын ажиллагааны хүрээнд 14 ажилтныг сувилагч мэргэжлээр суралцуулан гурван талт гэрээ хийн ажиллаж байна.

Найм. Хууль тогтоомжийн хэрэгжилт

Хүний нөөцийн алба нь

- Монгол улсын хууль 9, /Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Авлигны эсрэг хууль, Төсвийн тухай хууль гэх мэт/
- Засгийн газрын 3 тогтоол, /382, 240, 241 тогтоол,
- Төрийн албаны зөвлөлийн 3 тогтоол, /03, 600,
- Эрүүл мэндийн сайдын тушаал 5, /
- Эрүүл мэндийн сайдын албан даалгавар 1
- Ерөнхий захирлын тушаалаар батлагдсан журам 12, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилласан.

Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилт :

- 2023 оны эхний 11 сарын байдлаар Хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой Ерөнхий захирлын Б тушаал 484, А тушаал 35 боловсруулж батлуулсан.
- Төвийн хэмжээнд дагаж мөрдөх 3 төрлийн “Ур чадварын нэмэгдэл олгох” А/91, “Оны шилдэг шалгаруулах журам” А/136, “Шинэ ажилтныг туршилтын хугацаанд

чиглүүлж, дадлагажуулах журам” А/134 журмуудыг тус тус боловсруулан батлуулсан.

- Хөдөлмөрийн тухай хуулийн туршилтын хугацаагаар ажиллуулах 57 дугаар зүйлийг хэрэгжүүлэн төвд шинээр ажилд орсон 129 ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулж ажилласан.

Авлигын эсрэг хуулийн хэрэгжилт:

- Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөөг 5 зорилт 24 ажил төлөвлөн хэрэгжилтийг холбогдох газарт хугацаанд нь хүргүүлсэн.
- Хувийн ашиг сонирхол хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах 44 удирдах албан тушаалтныг хуулийн хугацаанд гаргуулан ажилласан.
- Удирдах албан тушаалтанд нэр дэвшиж буй ажилтны ХАСУМ-ыг Авлигатай тэмцэх газарт хянуулж дүгнэлтийг үндэслэн томилсон.
- Авлигын эсрэг соён гэгээрүүлэх арга хэмжээний хүрээнд:

ХАСУМ, ХАСХОМ гаргахад анхаарах асуудал

Ашиг сонирхлын талаарх ойлголт

Төрийн албан хаагчийн ёс зүй

Хувь хүний хөгжил манлайлал сургалтуудыг зохион байгуулж давхардсан тоогоор 482 ажилтан хамрагдсан.

- Авлигатай тэмцэх газраас санаачлан зохион байгуулсан “Нэгдье” аяны хүрээнд “Үгүй гэж хэлээд өөрчилье” 24 цагийн челленжэд нэгдэж 16 тасгийн 180 гаруй ажилтнууд оролцсон. Мөн АТГ-аас санаачлан хэрэгжүүлж буй үйл ажиллагааг дэмжин ажиллах-Авлигатай тэмцэх үйл ажиллагааг сурталчлан таниулах үнэн зөв мэдээ мэдээллийг бодит эх сурвалжаас түгээх зорилготой “Авлигатай тэмцэх газар” пэйж хуудсыг даган нэгдэхийг нийт ажилтнууддаа уриалж ажилласан.
- Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарласантай холбогдуулан “Шүүр” ажиллагааг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төвийн Ерөнхий захирлын А/66 тоот тушаалаар томилогдсон ажлын хэсэг дэд захирал, албаны дарга, эрх бүхий 10 албан тушаалтныг ажилд авсан материалд холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт хийсэн. Хяналтын дүнгээр ажлаас чөлөөлөгдөх ажилтан байхгүй.
- Мөн эмч эмнэлэгийн мэргэжилтнүүд эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлсний төлөө шан харамж бэлэг, албан бус төлбөр авахыг хориглосон зохицуулалтыг сурталчилсан агуулга бүхий контентыг Хуульч Г.Төгөлдөртэй хамтран хийж Хуульч Г.Төгөлдөр Facebook рaжe, Эх, нярай эмэгтэйчүүдийн үндэсний төв-II-ийн цахим хуудсанд 14 хоногийн хугацаатай байршуулсан.

- “Ёс зүйн зөрчилгүй хамт олон”-14 хоногийн аяны хүрээнд 9 үйл ажиллагааг төлөвлөн авлигын эсрэг соён гэгээрүүлэх чиглэлээр бүх алба, тасаг, нэгжүүд идэвхтэй оролцсон.
- Авлигын эсрэг хууль сурталчлах ажлын хүрээнд Хуульч Г.Төгөлдөртэй хамтран контент бэлтгэн гадаад дотоо цахим хуудсаар түгээн дэлгэрүүлсэн.

Засгийн газрын тогтоолын хэрэгжилт:

- Засгийн газрын 2023 оны 240, 241 дүгээр тогтоолын хэрэгжилтийн хүрээнд Ерөнхий захирлын А/112 дугаар тушаалаар төвийн ажилтнуудын үндсэн цалингийн хэмжээг шинэчлэн тогтоосон.
- 2023 оны эхний 10 сарын байдлаар төвийн Ерөнхий захирлын тушаалаар I улиралд нийт 301 ажилтанд 184,664,766 төгрөг, II улиралд 345 ажилтанд 192,728, 452 төгрөг, III улиралд 351 ажилтанд 172.423.614 төгрөгний урамшуулал
- Ур чадварын нэмэгдлийг 30 ажилтанд 10-25 хувиар
- Төрийн алба хугацааны нэмэгдэл 309 ажилтанд 1-25 хувиар 209,718,672 төгрөг
- Хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдлийг 289 ажилтанд 10 хувиар 228,889,236 төгрөг
- Ажил мэргэжил хавсран, хослон, орлон ажилласны нэмэгдлийг 21 ажилтанд 25-40 хувиар 120,364,061 төгрөг тус тус олгосон.

Эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилт

- 29.2 дахь заалтын дагуу өндөр насны тэтгэвэр тогтоолгосон 1 албан хаагчид 11,4 сая төгрөгийн тэтгэмжийг олгосон.
- Эрүүл мэндийн салбарт ажилласан 5 жил тутам 1 хоног ээлжийн амралтын хоног дээр олгох хуулийн заалтын дагуу 143 ажилтанд 1-6 хоногийн нэмэгдэл олгосон.

Төрийн албаны зөвлөлийн тогтоолын хэрэгжилт:

- Төрийн албаны 2019 оны 03 дугаар тогтоолын дагуу төвийн 33 алба тасгийн 137 албан тушаалын тодорхойлолтыг боловсруулан батлуулж ажилтан бүрээр уншиж танилцуулан баталгаажилтийг хийж ажилласан.
- 2023 оны 600 дугаар тогтоолын дагуу Төрийн албан хаагчийн хувийн хэргийн маягтыг шинэчлэх ажлыг эхлүүлж хэрэгжилт 70 хувьтай байна.

Ес. Программ хангамж

Хүний нөөцийн алба нь өдөр тутмын үйл ажиллагаандаа 6 төрлийн программ ашиглаж, хувь хүний мэдээллийг шивж оруулах, мэдээллийг шинэчлэх, хяналт хийх ажлыг тогтмол хийж байна.

- Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо цахим системд ажиллаж байгаа нийт 453 ажилтны үндсэн мэдээлэл, цалин хөлсний бүрэлдхүүн, албан тушаалын ангилал зэрэглэл, шатлал, нэмэгдэл хөлс, ажлын түүх (ажил эрхлэлт) зэрэг мэдээллийг оруулсан. Хүний нөөцийн шилжилт хөдөлгөөн, цалин хөлсний бүрэлдэхүүнд орсон өөрчлөлтийн мэдээллийг тухай бүр системд оруулан **нууц кодоор** нэвтрэн, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангаж ажиллаж байна.
- Нийгмийн даатгалын ерөнхий газрын e-ndaatgal.mn програмд ажилд орсон 151, ажлаас гарсан 73 ажилтны тушаалыг оруулсан.
- Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын <https://selection.1818.mn/> цахим системд 292 эмч, эмнэлгийн мэргэжилтний диплом, мэргэжлийн үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрөл, төрөлжсөн мэргэжлийн үнэмлэх хуулбар, ерөнхий мэдээллийг оруулж өгсөн.
- Авлигтай тэмцэх газрын Хувийн ашиг сонирхол болон хөрөнгө орлогын мэдүүлэг бүрдүүлэлтийн систем meduuleg.iaас
- Цаг ашиглалтын Timely программыг шинээр нэвтрүүлсэн.
- Эрүүл мэндийн хөгжлийн төв www.hr.hdc.gov.mn программ нь эрүүл мэндийн салбарын ажилтнуудад зориулан мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл цахимаар сунгах, шалгалтад бүртгүүлэх, салбарын хэмжээнд зохион байгуулагдах сургалтын зар, ажлын байрны зарыг байршуулах цахим сайт юм. Төвийн хэмжээнд 233 эмч, эмнэлгийн мэргэжилтэн нар уг системд бүртгэгдэж хүний нөөцийн алба нь баталгаажуулалт хийн хяналтыг тавин ажиллаж байна.

Арав. Дотоод, олон нийтийн үйл ажиллагаа:

- Удирдлагын шуурхай зөвлөгөөний нийт 42 удаагийн хурлын бэлтгэл ажлыг хангаж хурлын тэмдэглэл хөтлөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг танилцуулан ажилласан.
- Удирдлагын зөвлөлийн 8 удаагийн хурлын бэлтгэл ажлыг хангаж хурлын тэмдэглэл хөтлөн баталгаажуулалтыг хийсэн.
- Дэд захирлуудын зохион байгуулсан давхардсан тоогоор 40 удаагийн хуралд оролцсон.

- Спорт, урлагын тэмцээн наадамд зохион байгуулалтын ажлын хэсэг орж ажиллан бэсрэг наадамд баг хамт олноороо 2 дугаар байранд орсон.
- Бүх нийтийн их цэвэрлэгээнд 2 удаа оролцсон

Арван нэг. Албан хэрэг хөтлөлт

2023 оны 11 сарын 17-ны өдрийн байдлаар тус төвд нийт Ирсэн бичиг 606, Явсан бичиг 704 бүртгэгдсэн байна. Үүнээс:

Нийт: Ирсэн бичгийн:

Дээд газраас ирсэн бичиг, Эрүүл мэндийн сайдын тушаал, Албан даалгавар, Чиглэл, Тайлан, мэдээ ирүүлэх тухай, Гомдол шийдвэрлүүлэх тухай, Цахим сургалт, уулзалт, зөвлөгөөн, Эрдэм шинжилгээний бага хурал, гадаадын сургалт, хөтөлбөр, Албан шаардлага, зөвлөмж зэргийг хүлээн авч 146-Хариутай албан бичгийн хариуг хүргүүлсэн.

Нийт Явсан бичгийн:

Хариу хүргүүлэх тухай- 146

Тодорхойлолт -236

Хүсэлт уламжлах тухай, Бусад -322

Тушаал

Ерөнхий захиралын нийт 618 тушаал, шийдвэр гарсанаас А-137, Б-480 тушаал үйл ажиллагаанд мөрдөгдөн ажиллаж байна.

Өргөдөл гомдол шийдвэрлэлт

Тус төвийн захиргаанд нийт 332 өргөдөл, гомдол ирүүлсний буюу 97% нь захиргаа, хүний нөөцийн албанд ирүүлсэн байна. Үүнд:

Ажлаас гарах- 124

Сургалтын чөлөө- 3

Албан тушаал шилжин ажиллах хүсэлт- 7

Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбогдох- 5

Жирэмсний болон амаржсаны амралт- 26

Хүүхэд асрах чөлөө-17

Аавын /10 хоног/ чөлөө - 7

Тэтгэмж /нас баралт/-19

Чөлөөний хүсэлт, Бусад хүсэлт- 114

Хавсралт

Зураг

2023 оны Б тушаал

